



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 385

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, сэлбэгээр худалдах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 442,733,307.95 (дөрвөн зуун дөчин хоёр сая долоон зуун гучин гурван мянга гурван зуун долоон төгрөг ерэн таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, сэлбэгээр худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, худалдах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001278

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн  
38... дугаар тогтоолын хавсралт

"ДУЛААНЫ ДӨРӨВДҮГЭЭР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН  
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| №        | Хөрөнгийн нэр         | Нийт гүйлт /км/ | Ашиглалтад орсон он | Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл                                                               | Акталж, сэлбэгээр худалдах доод үнэ |
|----------|-----------------------|-----------------|---------------------|--------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------|
|          |                       |                 |                     | (төгрөг)                                                                                               |                                     |
| 1        | Бульдозер PR-732 L-01 | 9800            | 2004                | 442,733,307.95                                                                                         | 1,500,000.00                        |
| НИЙТ ДҮН |                       |                 |                     | 442,733,307.95                                                                                         | 1,500,000.00                        |
|          |                       |                 |                     | (дөрвөн зуун дөчин хоёр сая долоон зуун гучин гурван мянга гурван зуун долоон төгрөг ерэн таван мөнгө) | (нэг сая таван зуун мянган)         |